



**БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 4/5

Ингэттолгой

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн
төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18-р зүйлийн 18.1.2-ын “А”, “З” дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийг сурталчлан таниулах, орон нутгийн иргэдийн газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулахыг Сумын засаг дарга /Ш.Насандулам/-д даалгасугай.

3.Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн мастер төлөвлөгөө, Сумын дахин төлөвлөлттэй уялдуулан, орон нутгийн сонгуулийн дүнгээр байгуулагдсан ИТХ, Засаг дарга нь үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрөө тусган хэрэгжүүлж, үр дүнг сумын ИТХ-ын хуралдаанд танилцуулж байхыг сумын засаг дарга /Ш.Насандулам/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын дарга , тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  Х.ХҮДЭРЧУЛУУН